АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2023/16-НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор П.Цэцэгдулам<br>Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ....................

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....................3

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....................7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................10

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .................... **Error! Bookmark not defined.**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .................... **Error! Bookmark not defined.**

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .................... **Error! Bookmark not defined.**

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .................... **Error! Bookmark not defined.**

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .................... **Error! Bookmark not defined.**

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .................... **Error! Bookmark not defined.**

3.5.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт .................... **Error! Bookmark not defined.**

3.5.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл .................... **Error! Bookmark not defined.**

4. АУДИТЫН ТАЙЛАН .................... **Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл .................... **Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал .................... **Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .................... **Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .................... **Error! Bookmark not defined.**

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .................... **Error! Bookmark not defined.**

4.5 Төсвийн шууд захирагчийн аудитын дүнгийн талаар .................... **Error! Bookmark not defined.**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .................... **Error! Bookmark not defined.**

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....................11

5.1 Төлбөрийн акт ....................11

5.2 Албан шаардлага ....................11

5.2 Зөвлөмж ....................

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....................13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| БОАЖГ | Байгаль орчин аялал жуулчлалын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.24 № 140

танай ____________-ны № ____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэмандал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангаас нийт 22,901.3 мянган төгрөгийг иргэдийн саналд үндэслээгүй, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7.3, 4.7.5 дахь заалтуудтай нийцэхгүй, зөрчлийн дүн бидний тооцсон материаллагийн хэмжээнээс хэтэрсэн, аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн, мөрдөгдсөнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон

D:\2019\АЛБАН БИЧИГ\2021 он\2022 А4 toot.doc

тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогууд сумын төсвийн орлогод нэмэгдэж төвлөрсөн.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 6 зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 81.7 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

D:\2019\АЛБАН БИЧИГ\2021 он\2022 A4 toot.doc

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,329,731.6 | 1,082,576.3 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 347,000.5 | 533,837.4 |
| 33 | АВЛАГА | 517,068.6 | 313,095.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 465,662.6 | 235,643.6 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 12,097,230.6 | 11,057,549.5 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12,097,230.6 | 11,057,549.5 |
| 39200 | Биет хөрөнгө | 11,904,246.6 | 10,713,063.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 192,984.0 | 344,486.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 13,426,962.2 | 12,140,125.8 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 116,256.4 | 19,518.4 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 116,256.4 | 19,518.4 |
| 41300 | Өглөг | 100,546.0 | 19,398.4 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 15,710.4 | 120.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 13,310,705.8 | 12,120,607.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 13,310,705.8 | 12,120,607.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 3,769,558.0 | 1,403,360.5 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 3,769,558.0 | 1,403,360.5 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 0.0 | 177,814.0 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 7,217,415.4 | 10,444,578.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,323,732.4 | 94,854.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 13,426,962.2 | 12,140,125.8 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *| мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 6,170,238.1 | 11,286,937.2 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 448,215.1 | 729,688.6 |
| 110 | Орлогын албан татвар | 163,602.4 | 384,395.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 163,602.4 | 384,395.4 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 12.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 220,309.7 | 244,639.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 64,303.0 | 90,574.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 855,395.1 | 9,468,920.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 855,395.1 | 9,455,320.2 |
| 123 | Тусламж санхүүжилтийн орлого | 0.0 | 13,600.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,866,627.8 | 1,098,408.3 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,035,555.1 | 1,927,421.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,888,167.0 | 1,927,421.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,908,903.3 | 1,892,654.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,565,850.2 | 587,793.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 519,156.1 | 72,976.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 167,659.3 | 643,694.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 195,083.7 | 76,458.6 |
| 2105 | Нормативт зардал | 663,844.6 | 1,204.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 23,146.7 | 52,333.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,859.1 | 19,446.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 36,791.3 | 49,604.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 724,512.3 | 389,142.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 979,263.7 | 34,767.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 147,388.1 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 134,683.0 | 9,359,515.3 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 82,800.0 | 10,731,432.7 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 51,883.0 | -1,371,917.4 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 5,398,876.0 | 2,381,234.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 448,215.1 | 729,688.6 |
| 110 | Орлогын албан татвар | 163,602.4 | 384,395.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 163,602.4 | 384,395.4 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 12.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 220,309.7 | 244,639.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 64,303.0 | 90,574.2 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 22,307.0 | 18,255.5 |
| 1181 | Газрын төлбөр | 4,813.5 | 51,676.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 37,182.5 | 20,642.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 189,195.1 | 539,537.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 189,195.1 | 539,537.7 |
| 1201 | Тусламжийн орлого | 00.00 | 13,600.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,761,465.8 | 1,098,408.3 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,836,754.0 | 1,644,427.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,836,754.0 | 1,644,427.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,856,001.2 | 1,604,411.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,660,077.4 | 579,583.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 342,585.1 | 83,055.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 165,663.4 | 663,291.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 117,678.0 | 75,673.0 |
| 2105 | Нормативт зардал | 329,047.6 | 2,469.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 40,358.4 | 51,750.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,859.1 | 8,768.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 48,923.4 | 54,754.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,808.9 | 85,065.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 980,752.7 | 40,015.8 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 562,122.1 | 736,807.3 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 321,321.9 | 549,970.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 321,321.9 | 549,970.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 321,321.9 | 549,970.4 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -321,321.9 | -549,970.4 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -220,000.0 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 220,000.0 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 20,800.2 | 186,836.9 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 326,200.3 | 347,000.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 347,000.5 | 533,837.4 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 12,253,881.7 | 12,253,881.7 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,004,941.2 | 1,004,941.2 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,258,822.8 | 13,258,822.8 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 51,883.0 | 51,883.0 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 13,310,705.8 | 13,310,705.8 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 13,310,705.8 | 13,310,705.8 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 4,005.0 | 4,005.0 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,314,710.8 | 13,314,710.8 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 177,814.0 | 177,814.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -1,371,917.4 | -1,371,917.4 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 12,120,607.4 | 12,120,607.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,170,145.10 | 1,741,527.70 | 428,617.40 | 80.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,265,385.50 | 1,234,477.10 | 30,908.40 | 97.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,235,050.30 | 1,204,141.90 | 30,908.40 | 97.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 519,584.80 | 499,090.90 | 20,493.90 | 96.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,947.90 | 61,988.40 | 2,959.50 | 95.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 465,206.20 | 463,684.00 | 1,522.20 | 99.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 52,152.70 | 49,965.10 | 2,187.60 | 95.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 52,843.80 | 52,598.70 | 245.10 | 99.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,200.00 | 6,200.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,767.60 | 36,195.90 | 1,571.70 | 95.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,347.30 | 34,419.00 | 1,928.30 | 94.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30,335.20 | 30,335.20 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,335.20 | 30,335.20 | - | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 743,759.60 | 507,050.60 | 236,709.00 | 68.2 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 161,000.00 | 0.00 | 161,000.00 | 0.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,170,145.10 | 1,897,055.30 | 273,089.80 | 87.4 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,666,671.40 | 1,769,873.80 | (103,202.40) | 106.2 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 503,473.70 | 127,181.50 | 376,292.20 | 25.3 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 180,850.30 | -180,850 | 0.0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 331,129.80 | -331,130 | 0.0 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 173.00 | 173.00 | 0 | 100.0 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 3.00 | 3.00 | 0 | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 85.00 | 85.00 | 0 | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 85.00 | 85.00 | 0 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 54,271.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 54,271.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 54,271.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,303.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,843.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,125.0 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 54,271.4 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 54,271.4 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 0.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй. Залруулагдаагүй нийт 123,883.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч зөрчил арилгуулах 6 албан шаардлага хүргүүллээ.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тулган шалгахад 5 зээлдэгчтэй холбоотой 40,606.4 мянган төгрөгийн 2-8 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.”

<u>Шийдвэрлэсэн нь</u>: *Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

*3.1.2* Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулган шалгахад хадгаламжийн хүүгийн орлого 29,847.7 мянга, малын тоо толгойн албан татвар 10,279.5 мянга, гал зэвсгийн албан татвар 2,100.0 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 62.1 мянга, улсын тэмдэгтийн хураамж 346.6 мянга, ойн нөөц ашигласны төлбөр 265.3 мянга, газрын төлбөр 256.7 мянга, нэр заагдаагүй бусад орлого 647.8 мянга нийт 8 нэр төрлийн 43,805.7 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна

<u>Шийдвэрлэсэн нь</u>:*Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

*3.1.3 Эрдэнэмандал Шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа дэмжлэгт 13,600.0 мянган төгрөгийн ОНХС-аас олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7, 4.7.6 "Аливаа аж ахуй нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"-д зарцуулахгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; гэсэн заалтуудыг зөрчиж байна.*

<u>Шийдвэрлэсэн нь</u>:*Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

*3.1.4 Тайлант онд малчдын зөвлөгөөны хоол цайны зардалд 2,781.0 мянга, хүнс, бэлэгэнд 2,020.3 мянга, тоглолтын төлбөрт 1,200.0 мянга нийт 6,001.3 мянган төгрөгийг ОНХС-аас зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад, 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг зөрчиж байна.*

<u>Шийдвэрлэсэн нь</u>:*Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

*3.1.5 ОНХС-аас модны манаачийн урамшуулалд нийт 2,970.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7, 4.7.6 "Аливаа аж ахуй нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"-д зарцуулахгүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3. "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчиж байна.*

*Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

*3.1.6 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хууль, журмаар тогтоосон чиг үүрэгт хамааралгүй 3 ажилд нийт 16,900.0 мянган төгрөг зарцуулсан нь "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.6 "ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй", 4.6.1, 4.6.2, 4.6.3 дахь заалтуудыг зөрчиж байна.*

*Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрдэнэмандал сумын ТТЗ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрдэнэмандал сумын ТТЗ | 6 | 123,883.0 | 0 | 0 | 6 | 123,883.0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Эрдэнэмандал сумын ТТЗ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |